



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/343

Булган сум

┌ Зургийн зөвлөлтэй гэрээ шууд байгуулах ┐ эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан "Зураг төслийн жишиг үнийн дүрэм" БД 81-16-20, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай" IV/26 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.18 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/342 дугаар захирамжийн хавсралтын 9, 20, 22, 23, 24, 28, 33, 36 дах хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд нэг маягийн жишиг халуун усны зураг төсөв боловсруулах ажлыг 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөгөөр "ОСИБ ЗТ" ХХК, Булган сумын 1 дүгээр баг хүртэл 1 дүгээр контурын дулааны шугам татах ажлын зураг төсөв боловсруулах ажлыг 20,000,000 (хорин сая) төгрөгөөр "Уран үзэг" ХХК, Аймгийн Засаг даргын тамгын газрын конторын барилгын дотор засварын ажлын зураг төсөв боловсруулах ажлыг 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгөөр "Аркфило" ХХК, Сэлэнгэ сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны их засварын зураг төсөв боловсруулах ажлыг 20,000,000 (хорин сая) төгрөгөөр "Зууны гүүр" ХХК, Усан спорт сургалтын төвийн их засварын зураг төсөв боловсруулах ажлыг 19,000,000 (арван есөн сая) төгрөгөөр "Үүлэн прожект" ХХК, Ногоон хэв маяг бий болгох зорилгоор цахилгаан авто машин цэнэглэх станц бүхий авто зогсоолын нэг маягийн зураг төсөв боловсруулах ажлыг 16,000,000 (арван зургаан сая) төгрөгөөр "Үүлэн прожект" ХХК, 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 1:1000 масштабтай геодези, дэвсгэр зураг боловсруулах ажлыг 8,000,000 (найман сая) төгрөгөөр "Аржис инженеринг" ХХК, Булган аймаг дахь Цагдаагийн газрын замын хяналтын постын конторын барилгын их засвар зураг төсөв боловсруулах ажлыг 17,000,000 (арван долоон сая) төгрөгөөр "Нарлаг хөхий" ХХК-тай тус тус гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга)-д олгосугай.

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010002

2.Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "ОСИБ ЗТ" ХХК-ийн захирал (Ц.Мөнх-Эрдэнэ), "Уран үзэг" ХХК-ийн захирал (Ө.Эрдэнэгэрэл), "Аркфило" ХХК-ийн захирал Ц.Мөнхтулга, "Зууны гүүр" ХХК-ийн захирал Х.Дэлгэрмаа, "Үүлэн прожект" ХХК-ийн захирал Э.Алтаншагай, "Аржис инженеринг" ХХК-ийн захирал (Л.Амартүвшин)-д тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-д даалгасугай.

4.Дээрх ажлын санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний "Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах зардал" санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР